

**1905-1907 ОНЫ ОРОСЫН ХУВЬСГАЛ ДОРНО
ДАХИН БА МОНГОЛ ОРОНД НӨЛӨӨЛСӨН НЬ**

Ц. Пунцагноров

ШУА-ийн сурвалжлагч гишүүн

**1. Оросын анхдугаар хувьсгалын олон улсын ач холбогдол,
Дорно дахин хийгээд Монгол оронд түүний нөлөөлсөн хүчин зүйл**

Манжийн дарлалыг түлхэн унагааж Монгол орны төрийн тусгаар тогтнолыг тунхаглан зарласан 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь Оросын 1905-1907 оны хувьсгалын нөлөөтэй нягт холбоотой юм. XIX зууны эцэс XX зууны эхэн үед дэлхийн хувьсгалт хөдөлгөөний төв нь газар зүй, түүхийн хувьд бас Азийн орон болох Орос улсад шилжсэн нь Дорно дахины улс түмэнд юуны өмнө Оросын эзэн хаант улстай хил залгаа орнуудад ихээхэн хувьсгалжуулагч нөлөө үзүүлсэн юм. Оросын хувьсгал нь Европын төдийгүй Азийн харгис хүчний түшиг тулгуур болсон хаант засагт лут цохилт болжээ.

Азийн олон орны феодалын буюу хагас феодалын нийгмийн гүнд нийгэм-эдийн засгийн ахиц өөрчлөлт гарч нэг талаас дарлагдан мөлжигдсэн олон түмэн, нөгөө талаас империализм, түүнтэй сүлбээтэй дотоодын харгис хүчний хоорондохи зөрчил хурцадсан түүхэн нөхцөлд оросын хувьсгал өрнөсөн учир түүний үлгэр жишээ, туршлага нь Дорно дахинд өргөн нөлөө тусгалтай байсан юм.

В.И.Ленин, большевик намаас оросын анхдугаар хувьсгалын болон түүний дараах жилүүдэд явуулсан үйл ажиллагаа нь Дорно дахины ард түмний хувьсгалт тэмцэлд онол, практикийн асар их ач холбогдолтой байлаа. Ленин өөрийн зохиол бүтээлд дэлхийн хувьсгалт үйл явцын салшгүй хэсэг болсон үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинж чанар, түүхэн байр суурь, ач холбогдол хийгээд хөгжлийн хэтийн төлөвийг шинжлэх ухааны үүднээс тодорхойлжээ. Империализмын дарлал мөлжлөгт талхигдсан Дорно дахины орнуудын хөдөлмөрчин олон түмэн бол социализмын төлөө тэмцэлд пролетари нарын зүй ёсны холбоотон мөн гэж В.И.Ленин үзэж байсан юм. В.И.Ленин Дорно дахины орнуудын хүн амын дийлэнх олонхи нь болсон тариачдын империализм, феодализмыг эсэргүүцсэн тэмцэл нь дэвшилт, хувьсгалч шинж чанартай гэсэн дүгнэлт хийж тариачид бол пролетари нарын бодит холбоотон мөн болохыг үгүйсгэдэг троцкист онолын харгис мөн чанарыг уудлан харуулжээ.

Пролетарийн интернационализмын зарчимд тулгуурлан Лениний боловсруулсан большевик намын үндэстний асуудлаархи программ нь империализмд боолчлогдсон бүх улс түмний үндэсний болон ангийн ашиг сонирхлыг илэрхийлсэн юм. Үндэсний өөрөө засан тохинох эрх буюу үндэсний тусгаар тогтносон биеэ даасан улс байгуулах эрхийг тунхагла-

сан нь энэ программын нэн чухал зүйл байв. Социалистууд колони орнуудын хувьд өөрөө засан тохинох тухай лоозон дэвшүүлэх хэрэггүй, өөрөөр хэлбэл «Ажилчин байхгүй оронд ажилчны намын лоозон дэвшүүлэх нь дэмий» гэж үзэж байсан оппортунистуудын эсрэг Ленин шийдвэртэй тэмцэж байлаа. Ленин: «...ямар ч марксист хүн «Өөрөө засан тохинох» лоозонг ажилчидгүй...колони орнуудын талаар тавих нь дэмий бишээр барахгүй, заавал тавих хэрэгтэй юм»¹ гэж бичжээ.

Дорно дахины ард түмний биеэ дааж түүхээ бүтээх, эдийн засаг, нийгмийн дэвшлийг хангах чадварыг үгүйсгэж байсан социал-демократ, оппортунистуудын догм, арьс өнгөний үзэл онолыг Ленин бут цохисон юм.

Империализмын эрин үед Оросын пролетарийн тэмцэл, Дорно дахины ард түмний үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний хоорондох, уялдаа холбоо, харилцан нөлөөлөх явдал, хүчтэй болсон гэж Ленин цохон тэмдэглэж байв. Оросын 1905-1907 оны хувьсгалын нөлөөгөөр Азийн колони, хараат орны олон түмний аяндаа урсгалаар гарсан тархай бутархай хөдөлгөөн нь үй олног хамарсан хувьсгалт тэмцэл болон хувирав. Энэхүү үйл явцыг В.И.Ленин «Азийн сэрэл» гэж нэрэлсэн юм.

Ленин оросын анхдугаар хувьсгалын олон улсын ач холбогдлын тухай бичихдээ: «Азийн сэрэл, Европын тэргүүний пролетари нар засгийн эрхийн төлөө тэмцэж эхэлсэн нь ХХ зууны эхэнд даян дэлхийд түүхийн шинэ үе эхэлсний бэлэг тэмдэг болж байна»² гэжээ.

2. Монголын 1911-1912 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний шинж чанарт Оросын анхдугаар хувьсгал нөлөөлсөн нь

ХХ зууны эхний Монгол дахь үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн нь Оросын анхдугаар хувьсгалын нөлөөгөөр эхэлсэн Ази тивийн сэргээн өөдлөх үйл явцын бүрэлдэхүүн хэсэг нь юм. Оросын анхдугаар хувьсгал Монголд шууд нөлөөлөх болсны урьдчилсан нөхцөл нь Орос оронд капитализм хөгжиж XIX зууны сүүлийн хагаст тус хоёр орны хооронд худалдаа-эдийн засаг, улс төрийн харилцаа өргөжсөнтэй холбоотой юм. Сибирийн төмөр замыг байгуулсан явдал Монголыг Оросын зах зээлд улам ойртуулав. XIX зууны эцэс ХХ зууны эхэнд Оросын монопольт капитал Монгол оронд нэвтэрч эхэлсэн нь империализмын тогтнолын ерөнхий хандлагыг тусган илэрхийлж байлаа.

Хаант засгийн бодлого нь түрэмгий шинжтэй байсан хэдий боловч Орос орны нөлөө хүчтэй болсон явдал нь Марксын бичсэнээр Монголыг гадаад ертөнцөөс «Зэрлэгээр битүүмжлэн тусгаарлах» гэсэн манжийн бодлогыг таслан нураасны хувьд бодит чанараараа дэвшилттэй роль гүйцэтгэсэн юм. Үүний үр дүнд Орос оронд болж буй хувьсгалт үйл явдлын цууриа Монголд нэвтрэх, Монгол Оросын ард түмний харилцаа өргөжин бэхжих боломж нээгдлээ.

Хувь нийлүүлсэн «Монгол-оор» нийгэмлэгийн алтны уурхай, оросын үйлдвэрийн эздийн байгуулсан мал аж ахуйн түүхий эдийг боловсруулах жижиг гар үйлдвэрүүдэд орос, монгол ажилчид хөдөлмөрлөж байснаас гадна хилийн дагуу оршин суудаг хүн амын хооронд аж ахуйн нягт харилцаа бий болжээ.

Оросын хувьсгалын нөлөөгөөр Монголын ард түмний тусгаар тогтнолын төлөө тэмцэл шинэ шатанд гарч өргөн олон түмнийг хамарсан шинж чанартай болсон юм. Энэ бол ХХ зууны эхээр Монгол оронд Оросын түүхэн дэвшилттэй ролийг тодорхойлох гол зүйл мөн.

1. В. И Ленин. Зохиолууд, УБ, 1966. 23-р боть 60-р тал
2. В. И. Ленин. Зохиолууд, УБ. 19-р боть, 72-р тал.

Чэнь Чжун мэтийн хятадын хөрөнгөтний түүхчид бүр Юань Шикайн үеэс эхлэн хятадын эрх баригчдын эзлэн түрэмгийлэх бодлогыг зөвтгөх зорилгоор түүхийн үнэн байдлыг зориуд гуйвуулан, 1911 оны Монголд болсон үйл явдлыг Хаант Оросын хатгалгаар өчүүхэн бүлэг хүмүүсээс үйлдсэн эргэлт мэтээр дүрслэж байв.³

Өнөөгийн хятадын маоист түүхчид мөн дээрхи үзлийг баримталж байна. 1980 онд Тяньцзинд хэвлэгдэн гарсан «Хятадын товч түүх» номд Монголын ард түмний 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний тухай бичихдээ: «1911 оны 12-р сард Оросын зэвсэгт хүчний шууд дэмжлэгээр Гадаад Монголын хүрээ хотод лам Жавзандамба эх орноосоо урван тэрслэж Гадаад Монголын тусгаар тогтнол гэгчийг зарлаж өөрийгөө Монголын хаан гэж нэрлэв»⁴ гэжээ.

Гэтэл бодит баримт эдгээр гүтгэлгийг няцааж байна. 1911 оны үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний амжилтыг шийдвэрлэх нөхцөл нь түүнд өргөн олон түмэн зэвсэг барьж идэвхтэй оролцсон явдал мөн.

Феодалын эрх баригчид нийслэл Хүрээний ойр орчмын аймаг хошуудаас олон зуун цэргийг татан ирүүлээд манжийн амбанг хөөсөн юм. Манжийн эзэмшлийн сүүлчийн түшиг болсон Ховд хотыг чөлөөлөх тулалдаанд 5 мянга гаруй харц ард оролцжээ.

Тусгаар тогтнолыг тунхагласны дараа Өвөр Монголыг чөлөөлөхийн төлөө хятадын булаан эзлэгчидтэй ширүүн тулалдаан явуулахад ард олны зэвсэгт тэмцэл бүр ч өргөн цар хүрээтэй болсон юм. Тэр үеийн гадаад хэвлэлд Монголын нийт цэргийн тоог 30-50 мянга гэж тодорхойлж байв. «Монголчууд цэрэгт маш дуртай явж цугларах газрын зүг олон замаар шинэ цэргүүд тасралтгүй цувж байна гэж Монголоор сүүлийн хэдэн сард аялсан хүмүүс мэдээллээ. Манай цэрэг монголчуудыг ялж байгаа тухай хятадын сонинд өдөр бүр бичиж байна. Гэтэл үнэн хэрэг дээрээ эхлэхээсээ аваад адаг хүртэл Монголчууд удаа дараа амжилт олсон юм»⁵ гэж Хятадын «Ше Хебао» сонин 1912 оны 9-р сарын 28-ны дугаарт бичиж байв.

Хятадын хөрөнгөтөн, өөрөө манжийн дарлалаас дөнгөж ангижраад АНУ болон өрнөдийн бусад империалист гүрний дэмжлэгтэйгээр Монголд ноёрхлоо тогтоохыг эрмэлзсэн билээ. Монголыг эзлэх гэсэн хятадын эрх баригчдын санаархал ямар ч үндэсгүй гэдэг нь илэрхий юм. Үүнийг өрнөдийн эрдэмтэд, хятадын бодлогыг судлагч нар ч нотолж байна. Тухайлбал Оуэн Латтимор: «Хятад улс нийт Монгол орныг байлдан дагуулсан буюу хяналтаа ч тогтоож байсан үе бүхий л түүхийн турш үгүй юм»⁶ гээд харин «Манж нар XVII зууны үед, эхлээд Хятадыг дараа нь Монголыг тус тусад нь эзэлсэн юм. Манжийн хаанчлал унасаны дараа энэхүү зохиомол харилцаа тасарсан байна. Хятад Бүгд Найрамдах Улс болохоор зориглож байсан бол Монгол орон өөрийн замаар явах тавилантай байлаа»⁷ гэж бичжээ. Монголчууд бол хятадын хувьсгалыг бэлтгэсэн хүмүүстэй ямар ч харилцаа холбоогүйгээр, хятадад хувьсгал эхлэхээс өмнө Жавзандамба хутагтыг Монголын эзэн хаанаар тунхагласныг Оуэн Латтимор тэмдэглэжээ.⁸

3. «Чэнь Чжун «Гадаад Монголын ойрхи үеийн түүх» Бээжин-Шанхай 1922

4. «Чжунго цзяньши», Тяньзин, 1980 490-р талд.

5. Кигаи и Япония (обзор периодической печати) № 170 . Хабаровск, 14. XII. 1913

⁶Owen Lattimore. The Mongols of Manchuria. N V, 1934 p 311

⁷Owen Lattimore, Nomads and Commissars NY 1962 p. 50

⁸Owen Lattimore, Nationalism and Revolution in Mongolia, Leiden 1955 p. 52

Хятадыг судлагч Эдмунд Клабб (АНУ) Монголд санаархсан хятадын өнгөлзлөг зохиомол юм гэж бичихдээ: «Юань Шикай хуучин манжийн эзэнт улсын бүхий л нутаг дэвсгэрийг эзэмших эрхийг Хятадын Бүгд Найрамдах Улсад илжүүлж «Хятад» гэдэг ухагдахуунд хятадын хан үндэстний зэрэгцээ Манжуур, Монгол, Баруун хязгаар, Төвдийг багтаасан зүйл ангийг манжийн хаанчлалыг огцруулах тухай баримт бичигт санаатайгаар оруулсан юм. Гэтэл Монголын тал «Хятад» гэдэг улс төрийн бие махбодитой биш зөвхөн Манжийн хаан ширээтэй холбооны харилцаатай байсан гэж үзэж байв»⁹ гэжээ.

Манжийн дарлалыг устгаж төрийн тусгаар тогтнолыг тунхагласан нь нийт ард түмний эх оронч, үндэсний нэгдлийн үзэл санааг бадруулав. Энэ тухай «Далекая окраина» сонинд 1913 оны 12-р сард: «Халхын монголчуудтай анх танилцахаас эхлэн, тэдний боолчлогдсон энгийн номхон нүүдэлчний урьдын дүр байдал өөрчлөгдөн цогтой сэргэлэн байдлаар со- лигдсоныг ажиглаж болно. Өөрийгөө мэдрэх ухамсрын өндөр дуу хоолой сонсогдож, үндэсний санаа сэтгэл оргилж байна. Эдүгээ «Бид Монголчууд», «Манай ард түмэн», гэсэн үгийг монголчуудаас олонтаа сонсож болно»¹⁰ гэжээ.

Мөн түүнчлэн «The Seul Press» сонин: «Монголын цэрэг Чуулалт хаалга, Долон нуур, Суйюань=чэний чиглэлд довтлож байгаа гурван цуваа болон хуваагджээ. Монголын отрядыг арын албаны төрөл бүрийн ажил хийдэг эмэгтэйчүүд дагаж явна. Үүний үрээр олон тооны цэрэг жинхэнэ жагсаалын алба хааж байгаа юм. Эмэгтэйчүүд оногдсон үүргээ гүйцэтгэхийн төлөө амь бие хайргүй зүтгэж байна»¹¹ гэж 1913 оны 10-р сард бичиж байв.

Оросын хаант засгийн цэргийн зөвлөхүүдийн ажлыг шалгасан генерал Мартынов европ маягаар сургасан дайсны давуу хүчийг зэвсэг муутай ч гэсэн олонтаа ялж байсан монголын цэргийн эрэлхэг чанарын тухай мэдээлэн, нийслэл Хүрээний гарнизоны цэргээс Өвөр Монголд хятадуудтай байлдахаар сайн дураар очиж байсныг бас тэмдэглэжээ.¹²

Ард түмний олон үеийн хүсэл мөрөөдлийг тусган илэрхийлж, нэгдмэл Монгол улсыг байгуулах гэсэн Ар, Өвөр Монголын ард олны тэмцэл нь Азид хөрөнгөтний ардчилсан хувьсгалын эрин үеийн эхийг тавьсан 1905 оноос хойших дэлхийн дахины үйл явдлын дотор «Хөрөнгөтний ардчилсан үндэсний өдий төдий хөдөлгөөний сэргэлт, үндэсний тусгаар тогтносон, үндэсний нэгдмэл улс байгуулах эрмэлзлэлийг сохор хүн л олж харахгүй байж болох юм»¹³ гэсэн Лениний дүгнэлтийг нотолж байна.

Хөдөлмөрчин ардууд өөрийн улс төрийн дайчин нам үгүй, пролетарийн хөдөлгөөнтэй харилцаа холбоогүй байснаас гадна шарын шашны нөлөө зонхилж байсан нөхцөлд Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг хар шар феодалууд толгойлж ангийнхаа байр суурийг бэхжүүлэхийг оролджээ. Үндэсний нэгдмэл улс байгуулж чадаагүй гол шалтгаан хоцрогдсон буурай орнуудыг мөчлөн салгаж колоничлон боолчлох империалист бодлого тэр үед хувиаргүй ноёрхож байсантай холбоотой юм. Нэг ч капиталист орон Монголын тусгаар тогтнолыг хүлээн завшөөрөөгүй билээ. Хаант Орос нь Монголыг автономит эрхтэй улс болгосон тэгш биш гэрээг богд гэгээний засгийн газарт тулган хүлээлгэсэн юм.

⁹О. Edmund Clubb, China and Russia NU and London, 1971, p 1506

10. Китай и Япония. (...) Обзор периодической печати. № 70. Хабаровск 14 декабря 1913 г.

11. Мөн тэнд.

12. Мөн тэнд.

13. В. И. Ленин. Полн. соч ., т, 25., стр 269.

3. Оросын хувьсгал Моигол оронд нөлөөлсөн замын тухай В.И.Ленин Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийн хэтийн төлөвийн тухай

Тусгаар тогтнол тунхагласанаас хойш Оросын анхдугаар хувьсгалын үзэл санаа Монголд бүр ч хүчтэй нөлөөлөх болов. Үндэсний төр байгуулагдсанаар Монгол, Оросын эдийн засгийн харилцаа өргөжин тус улсыг дэлхийн капиталист зах зээлийн хүрээнд цаашид татан оруулж эрин үеийн шинэ үзэл санаа, шинэ хандлага нэвтрэхэд дөхөм болсон юм.

Тухайлбал, Оросын зөвлөх С. А. Козины оролцоотойгоор Налайхын нүүрсний уурхайг ашиглан хэвлэх үйлдвэр, дарханы газрыг байгуулжээ. Түүнчлэн цахилгаан мэдээний шинэ шугам барьж Хүрээнд анх удаа цахилгаан гэрэл, телефон утасны харилцаа бий болов. Жижиг үйлдвэрүүдэд монгол, орос ажилчид мөр зэрэгцэн хөдөлмөрлөж байв. Монголчуудын дотроос хэвлэх үйлдвэрийн ажилчин, холбоочин гэх мэт техникийн мэр- гэжлийн хүмүүс бий болж эхлэв.

Ерөнхий сайд Намнансүрэн, Гадаад Явдлын Яамны сайд Ханддорж гэх зэрэг Монголын төрийн зүтгэлтэн Орос оронд айлчилж ирээд эдийн засаг, засаг захиргааны талаар «Орос маяг»-ийн зарим өөрчлөлт хийх гэж оролдов. Монголын засгийн газрын дэргэд орос улстай думтай төстэй хоёр танхим бүхий зөвлөлдөх байгууллага улсын хурал байгуулжээ. Хурлын доод танхимд багтсан яамдын бага тушаалын түшмэд, албан хаагчид нь ард олны байдлыг ямар нэг хэмжээгээр тусган улс орны эдийн засгийг шинэчлэхэд чиглэсэн санал шүүмжлэл гаргаж байв. Гэвч хамжлагат ёсыг хэвээр хадгалах гэсэн хар, шар том феодалаас бүрдсэн дээд танхим дэвшилт бүх саналыг няцааж байв.

Феодалын Монгол нь олон засаг хошуу болон хуваагдаж байсан нөхцөлд Орос цэргийн зөвлөхүүдийн оролцоотой сургасан монголын цэрэг бол төр улсыг төвлөрүүлэн нэгтгэх хэрэглүүр болж байв. Цэрэг бол тэр үедээ хүн амын бичиг үсгийн боловсролтой хэсэг нь байсан юм. Цэргийн мэргэжилтэй ард ангийн гаралтай хүмүүсийн дотроос 1921 оны ардын хувьсгалын удирдагч Дамдины Сүхбаатар тодорсныг онцлон тэмдэглэх хэрэгтэй.

Үндэсний улс байгуулагдсаны дүнд төрийн түшмэдийн давхраа үүсч тэдний дотор дэвшилт санал бодолтой хүмүүс ч байлаа. Гадаад Явдлын Яамны дэргэд сургуулийн хэргийг эрхлэх газрыг байгуулан оросоос мэргэжилтэн урьж бага, дунд сургуулийн дүрмийг боловсруулжээ. Нийслэл Хүрээнд анх удаа төрийн сургууль нээснээс гадна Орос оронд суралцуулахаар анхны хэсэг залуучуудыг явуулжээ.

Эдийн засаг, нийгмийн энэ мэтийн ахицын үр дүнд жижиг хөрөнгөтний зэрэгцээ ардчилсан санаа бодол бүхий сэхээтнийг хамарсан хотын дунд давхарга өсөн бэхжив.

Энэтхэг мэт Азийн зарим орны туршлагаас үзэхэд хоцрогдсон колони, хараат оронд чухамхүү хотын дунд давхрага нь ардчилсан хувьсгалт хүчнийхнийг төрүүлж бичиг үсэг мэдэхгүй олон түмний дунд шинэ дэвшилтэт үзэл санааг нэвтрүүлэгч нь болдог байна. Нийслэл Хүрээнд голчлон төвлөрсөн, хотын дунд давхрааныхан, түүний дотор ардчилсан үзэлтэй сэхээтнүүд, хэдийгээр нийгэмд эзлэх байр суурь, тооны хувьд доривтой биш байсан боловч тус орны улс төрийн амьдралд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх болжээ.

Малчин ардтай мах цусны холбоотой, тэдний ангийн эрх ашгийг тусгасан дэвшилт сэхээтнүүд оросын анхдугаар хувьсгалын нөлөөгөөр шинэ шатанд гарсан үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн дэх хувьсгалт ардчилсан урсгалыг төлөөлж байлаа. Улс орныхоо хөгжил дэвшлийг хангах

арга замыг хайж байсан монголын хувьсгалт ардчилсан хүчний улс төрийн үзэл санаа бүрэлдэхэд хаант засгийн суурийг ганхуулсан оросын хувьсгалын үлгэр туршлага шууд нөлөөлсөн юм. Хувьсгалт ардчилсан хүч нь улс орны тусгаар тогтнолын төлөө тэмцээд зогсоогүй үеэ өнгөрөөсөн феодалын хамжлагат ёсыг эсэргүүцэн нийгмийг ардчилсан ёсоор өөрчлөн байгуулахын төлөө тэмцэж байв. Ардчилсан сэхээтний төлөөлөгчид Орос оронтой харилцаагаа өргөжүүлэн бэхжүүлж тэндээс орчин үеийн үйлдвэрлэл, шинжлэх ухаан, техникийн ололтоос авч хэрэглэх шаардлагатай гэж үзэж байв. Мөн тэд ард түмний дунд гэгээрэл боловсрол, шинжлэх ухааны мэдлэгийг бүхий л аргаар дэлгэрүүлэхийг эрмэлзэж байлаа.

Тусгаар тогтнолыг тунхагласны дараа оросын соёлын нөлөөгөөр үүссэн тогтмол хэвлэл Монголын тэргүүний хүмүүсийн санаа бодлыг илэрхийлж байв. «Шинэ толь» сэтгүүл, «Нийслэл Хүрээний мэдээ» (1914 оноос) гэх зэрэг хэвлэл нь үзэл санаа-улс төрийн хувьд гол төлөв хөрөнгөтний ардчилсан, соён гэгээрүүлэх шинж чанартай байлаа. Эдгээр сонин, сэтгүүлд улс орон лам ноёдгүйгээр амьдарч чадна, феодалын бурангуй засгийг халж Бүгд Найрамдах Улс байгуулах шаардлагатай гэсэн санааг агуулсан зүйл ч нийтлэгдэж байлаа. Ийнхүү Оросын хувьсгалын феодалыг эсэргүүцсэн, ардчилсан хувьсгалт үзэл санаа тогтмол хэвлэлээр дамжин Монгол оронд нэвтэрч эхэлсэн юм.

Монголын ард түмний эрх чөлөөний тэмцэлд оросын анхдугаар хувьсгалын үзүүлсэн нөлөөний тухай ярихад Монголд амьдарч, тэмцэж байсан оросын хувьсгалчдын гарамгай ролийг цохон тэмдэглэх хэрэгтэй.

1905-1907 оны хувьсгал ялагдсаны дараа оросын хувьсгалчид, тэдний дотор большевикууд, монголын нутагт түр хоргодож байсан билээ. Тэд монголчуудтай нөхөрсөг харилцаа тогтоон зарим нь монголоор ярьдаг болж, хувьсгалт үзэл санааг түгээж байв.

1905-1907 оны Оросын хувьсгалд идэвхтэй оролцож хаант засгийн мөрдлөг хавчлагаас зайлан Монголд ирж хоргодсон хүмүүсийн дотор МАХН-ыг үүсгэн байгуулах, Монгол-Зөвлөлт Оросын хооронд ах дүүгийн найрамдал, хамтын ажиллагааг тогтооход үнэлж баршгүй тусламж үзүүлсэн оросын хувьсгалчид байсан юм. Тэдний заримын нэрийг дурьдвал:

Кучеренко Михаил Иванович, хэвлэх үйлдвэрийн ажилчин, 1906-1908 онд цэргийн алба хааж байхдаа цэргийн үймээнд оролцож байжээ. 1912 онд Монголд ирж Орос-Монголын хэвлэх үйлдвэрт үсэг өрөгчөөр ажиллав. Хожим нь Хүрээн дэх анхны большевик бүлгийн гишүүн болжээ. Энэ бүлэг Зөвлөлт Оростой байнгын харилцаа тогтоож, монголын хувьсгалчдын үйл ажиллагаанд ихээхэн тусламж үзүүлсэн юм.¹⁴

Гембаржевский Яков Васильевич 1905 онд Украины хувьсгалт хөдөлгөөнд оролцсоны учир баривчлагдан Сибирьт цөлөгдөж Эрхүүгийн төв гянданд 8 жил хоригджээ. Нягтлан бодогч мэргэжилтэй энэ хүн 1914 онд Монголд ирж цайны худалдаа эрхэлдэг Оросын хувийн пүүсэнд ажиллаж байв. Улс төрийн хувьд найдваргүй гэж тооцогддог Гембаржевский хаант Оросын ерөнхий консулын газар сар бүр бүртгүүлж байх үүрэгтэй байлаа.¹⁵

Черепанов Иннокентий Николаевич Бүр 1900 онд хувьсгалт үйл ажиллагаагаа эхэлжээ. Тэнгисийн цэрэг байхдаа 1905 онд «Потемкин» хуягт онгоцонд гарсан бослогод оролцсоны учир хаант засгаас цаазаар алах ял

*. «Шинэ толь бичиг». 1913. № 13, «Нийслэл Хүрээний мэдээ» 1917, № 48,

14. 1946 онд Москва хотноо хувьсгалчийн бэлбэсэн гэргий Мария Алексеевна Кучеренкотой зохиогчийн ярилцсан ярианаас.

15. Мөн тэнд.

загдсныг хүнд хүчир хөдөлмөр хийх ялаар сольжээ. Черепанов тэндээс оргон Монголд ирж Разин Василий Михайлович гэдэг нэрээр нуугдсан байна.¹⁶

Кучеренко, Гембаржевский, Черепанов нар Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэлд амь насаа зориулсан юм.

1904 оноос ОАСДН-ын гишүүн, Оросын гурван хувьсгалд оролцсон буриадын цогтой хувьсгалч Ранжуров Цыремпил Цыремпилович (1884-1918) нэг үе Монголд амьдарч байсныг тэмдэглэх хэрэгтэй. Хувьсгалт хөдөлгөөнд оролцсон учир 1906 онд буудан алах ял заагдсаныг 10 жил хүнд хүчир хөдөлмөр хийх ялаар сольжээ. Ялаа эдлэж дуусаад Ранжуров Монголд ирж алтны уурхайд ажиллаж байсан байна.¹⁷

Монголд амьдарч байсан оросын хувьсгалчдын үйл ажиллагааны ачаар оросын пролетарийн тэмцэл, Монголын ард түмний эрх чөлөөний хөдөлгөөний хооронд шууд харилцаа холбоо тогтох бодит бололцоо анх удаа нээгджээ.

Оросын пролетари нарын хувьсгалт тэмцэл нь уг чанараараа Монголыг хаант оросын империалист хөрөнгөтний колоничлох оролдлогоос чөлөөлөхөд чиглэж байжээ. Хаант засгаас Монголд явуулж байсан түрэмгий бодлогыг большевик нам шийдвэртэй эсэргүүцэж «Их Оросын ажилчин бид Монголоос тонилох зайл гэж засгийн газраасаа шаардах ёстой»¹⁸ гэж Ленин 1916 онд бичжээ.

В.И.Ленин социалист хувьсгалын тухай суут онолоо боловсруулахдаа, Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийн хэтийн төлөвийн асуудалд ихээхэн анхаарч 1916 онд «Марксизмыг дууриах гэж хөглөсөн тухай, империалист эдийн засгийн тухай» гэдэг зохиолдоо Монгол болон бусад хоцрогдсон орнууд тусгаар тогтнолоо олж авсны дараа капитализмыг нийгэм-эдийн засгийн байгууллын хувьд алгасан социализмын замаар замнаж болох юм гэсэн дүгнэлт хийжээ.

Пролетарийн хувьсгал ялсны дараа хоцрогдсон орны хөдөлмөрчдөд пролетарийн диктатурт улсаас ах дүүгийн интернационалч тусламж үзүүлнэ гэж Ленин заасан юм: «Бид бол Монгол, Перс, Энэтхэг, Египетчүүдтэй ойртон нийлэхийг бүх хүчээрээ чармайх бөгөөд эс тэгвэл Европ дахь социализм батгүй болох тул ингэхийг өөрийн үүрэг, өөрийн эрх ашиг гэж бид үзэж байна. Биднээс илүү дарлагдан хоцрогдсон эдгээр улс түмэнд «соёлын тусламжийг сэтгэл харамгүй үзүүлэхийг...буюу өөрөөр хэлбэл машин хэрэглэх, хөдөлмөрөө хялбарчлах, ардчилал, социализмд тэднийг шилжихэд нь туслахыг бид хичээнэ»¹⁹ гэж бичжээ.

Оросын анхдугаар хувьсгалын сургамжаас үндэслэж В.И.Лениний хийсэн энэхүү урьдчилан харсан дүгнэлт үнэн зөв болохыг ЗХУ-ын ах дүүгийн тусламж дэмжлэгтэйгээр капиталист биш хөгжлийн замыг туулан социализмд шилжсэн БНМАУ-ын туршлага яруу тод нотолж байна.

Империализмын үеийн анхны ардын хувьсгалыг хошуучилж, дараа нь Аугаа их Октябрийн социалист хувьсгалын ялалтын тугийг мандуулсан Оросын пролетари нар Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийн найдвартай холбоотон, баттай түшиг тулгуур нь болсон юм.

Марксизм-ленинизмийн үзэл санаагаар зэвсэглэсэн Монгол Ардын Хувьсгалт Намын түүхэн гавьяа нь Монголын ард түмний эрх чөлөөний

16. «Известия Улан-Батор хото» № 27(272), 3 апреля 1927 г.

17. Борцы за власть Советов в Бурягии. Улан-Үдэ, 1967, стр 31—32.

18. В. И. Ленин. полн. собр. соч. т, 21. стр 125—126.

19. В. И. Ленин. Зохиолууд. 23-р боть. 62-р тал.

тэмцлийг олон улсын пролетарийн хөдөлгөөн, юуны өмнө Зөвлөлт Оросын хувьсгалт тэмцэлтэй холбож чадсанд оршино.

Ардын эрхт Монгол улс, Зөвлөлт Оросын хооронд үүсэн тогтсон ах дүүгийн харилцаа холбоо, хамтын ажиллагаа нь пролетарийн интернационализмын зарчмыг социалист хөдөлгөөний лоозонгоос өнөө үед хүн төрөлхтний хөгжил дэвшилд шийдвэрлэгч нөлөө үзүүлж байгаа материаллаг хүч болгон хувиргахад жинтэй хувь нэмэр оруулжээ.

Монголын ард түмний эрх чөлөөний тэмцлийг ийнхүү Оросын пролетарийн хөдөлгөөнтэй нягт холбох урьдчилсан нөхцлийг тавихад Оросын анхдугаар хувьсгал асар их нөлөө үзүүлсэн юм. Энэ нь Монгол-Зөвлөлтийн эвдэршгүй найрамдал бол түүхийн болон анги нийгмийн гүн гүнзгий үндэстэй, хувьсгалч яруу алдарт уламжлалтай гэдгийг нотлон харуулж байна.

ВЛИЯНИЕ РУССКОЙ РЕВОЛЮЦИИ 1905-1907 гг. НА ДАЛЬНИЙ ВОСТОК И МОНГОЛИЮ

(р е з ю м е)

В статье члена-корреспондента Академии наук МНР П.Пунцагнорова анализируются факторы непосредственного влияния первой русской революции на Монголию. Подвергается критике тенденциозные высказывания китайских и западных авторов, изображающих события 1911 года как «верхушечный переворот», инспирированный извне, показывается абсолютная беспочвенность территориальных и других притязаний Китая к Монголии.

В статье подчеркивается огромное значение для монгольского народа становление центра мирового революционного движения в России и то прогрессивное влияние, которое способствовало социально-экономическим и культурным сдвигам в Монголии, зарождению революционно-демократического течения в национально-освободительном движении.

В результате расширения экономических и культурных связей между обеими странами, особенно благодаря представителям русского рабочего класса, жившим и трудившимся в Монголии, впервые появилась перспектива установления союза национально-освободительной борьбы аратских масс с пролетарским движением, что стало возможным в новую историческую эпоху, открытую Великой Октябрьской социалистической революцией.

Нерушимая монголо-советская дружба имеет глубокие исторические и социально-классовые корни, впитала в себя все лучшее и прогрессивное, что было во взаимоотношениях между Россией и Монголией в прошлом.